



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/42

Амардалай

┌ Автотээвэр болон өөрөө явагч хэрэгслийн ┐
шинэчилсэн бүртгэл, техникийн хяналтын улсын үзлэг,
тооллого, албан татвар, төлбөр хураах тухай

Монгол Улсын Автотээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хуулийн 7 дугаар зүйлийн 7.1. Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 9.3, Авто замын тухай хуулийн 12.1.3, Аймгийн Засаг даргын 2020 оны А/27 дугаар захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг: Дэлгэрцогт сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн эзэмшилд байгаа бүх төрлийн авто тээврийн хэрэгслийн бүртгэл, албан татвар, төлбөр хураамжийг 2020 оны өдрүүдэд зохион байгуулсугай.

Хоёр: Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн бүртгэл, албан татвар төлөх, хураах, үзлэг тооллого явуулах комиссыг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: З.Наранмандах /Засаг даргын орлогч/

Нарийн бичгийн дарга: Б.Санжаасүрэн /Татварын байцаагч/

Гишүүдэд: П.Мөнхзориг /1-р багийн Засаг дарга/

Г.Сосорбурам /2-р багийн Засаг дарга/


П.Түвшинсайхан /3-р багийн Засаг дарга/

Л.Отгонбаатар /Хэсгийн төлөөлөгч/

Б.Насанжаргал /Хэсгийн цагдаа/

Гурав: Автотээврийн хяналтын улсын үзлэгт сумын нутаг дэвсгэрт хөдөлгөөнд оролцож байгаа болон оролцохгүй байгаа тээврийн хэрэгслийг бүрэн хамруулах талаар зохион байгуулан ажиллахыг Комиссын дарга /З.Наранмандах/, хэсгийн төлөөлөгч /Л.Отгонбаатар/, хэсгийн цагдаа /Б.Насанжаргал/ нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ДОЛМОНБААТАР

4880100104